БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН МУЗЕЙ
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Ш. Ногайн гудамж,
Утас/Факс:(976) 7042-2908,
E-mail:bayanulgii_mus@monheritage.mn

2026.07.21 № 57

танай 2026.06.04 -ны № 01/361 -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

Баян-Өлгий аймгийн Музейгээс "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам"-ын дагуу үнэт дурсгалт нэр дэвшүүлэх 5 дурсгалын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудас

ЗАХИРАЛ О.АЙСАУЛЕ

9006338 8317140135

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН МУЗЕЙГЭЭС “ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ”

ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

2026 оны 07 дугаар сарын 21-ний өдөр

д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	Журмын 2.1.6 (УБМС-ийн дугаар)	Журмын 2.1.5 (Судлагдсан, сурталчлагдсан байдал)	Саналын үндэслэл
	Элгэн дээл	БӨМ1960.0.2	1	Захны у - 44см. Цээжний өр - 30см. Ханцуйн өр - 12см. Хормойн өр - 49см	0055901	-Музейн танилцуулга. УБ., 2011 он. х.7 -Қазақтың этнографиялық категориялар, ұғымдар мен атаулырының дәстүрлі жүйесі энциклопедия “2 Е-И” 2012 жыл. 232 бет (хуудас 232). -Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II. УБ., 2014 он. х.198 -Музейн танилцуулга. БӨ., 2017 он. х.7 -Өлгий нутгийн өвөрмөц өв соёл. УБ., 2023 он. х.118	Энэхүү элгэн дээл нь казах үндэстний уламжлалт хувцасны өвөрмөц хийц, арьс шир боловсруулах уламжлалт арга технологи болон гар урлалын өндөр түвшнийг хадгалсан үзмэр юм. Угсаатны зүйн урлагийн өндөр үнэ цэнтэй бөгөөд казах түмний ахуй, хувцасны соёлыг төлөөлөх ховор дурсгал учир “Үнэт дурсгалт зүйл”-ийн зэрэглэлд нэр дэвшүүлж байна.
	Саукеле	БӨМ1960.0.186	1	Магнайн хэсгийн хүрээний у - 7,5см 2 талын улаан бүчний у - 22,5см Ар талын шилэвчний у - 58см Ар талын шилэвчний өр - 20см	0057758	-Музейн танилцуулга. УБ., 2011 он. х.5 -Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II. УБ., 2014 он. х.196 -Музейн танилцуулга. БӨ., 2017 он. х.7 -Өлгий нутгийн өвөрмөц өв соёл. УБ., 2023 он. х.115	Саукеле болон нөмрөг нь казах үндэстний хуримын зан үйл, гэр бүлийн ёс заншил, эмэгтэй хүний нийгмийн байр суурь, амьдралын шинэ үе шатыг бэлгэдсэн уламжлалт хувцасны цогц дурсгал бөгөөд хийц, урлал, материал, гоёл чимэглэлийн хувьд өндөр түвшний гар урлалын өвийг

				Унжуулганы у - 154см Унжуулганы өр - 15,5см			илэрхийлсэн ховор нандин соёлын үнэт өв юм. Түүнчлэн энэхүү хос дурсгал нь уламжлалт хувцасны хэлбэр, ур хийц, бэлгэдэл, хэрэглээний онцлогийг бүрэн хадгалсан, дахин давтагдашгүй түүх, угсаатны зүйн ач холбогдол бүхий эх хэрэглэгдэхүүн учраас “Үнэт дурсгалт зүйл”-ийн зэрэглэлд нэр дэвшүүлж байна.
	Нөмрөг	БӨМ1960.0.15	1	Захны у - 14см. Цээжний өр - 37см. Суганы өр - 30см. Ханцуйн өр - 7,2см. Хормойн өр - 63см. Урт- 156 Өргөн- 268.3	0043461	-Қазақтың этнографиялық категориялар, ұғымдар мен атаулырының дәстүрлі жүйесі энциклопедия “2 Е-И” 2012 жыл. 292 бет (хуудас 292). -Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II. УБ., 2014 он. х.196	
	Мөнгөн тоногтой хуйтай хутга	БӨМ1960.0.59 (1,2,3 а, б. 4 а, б. 5)	7	Их биеийн у - 46см. Хутганы у - 44,7см. Өр - 2,6см. Бариулын мөнгөн хээний өн - 3,3см. өр - 3,8см. Хутганы бариулын эврэн ишний өр - 3,2см. Хутганы төмөр үзүүрийн у - 29,8см. Хуйны өр - 4см. У - 33,8см. Амсарын дм - 4см. Савхны у - 41,9см.	0056253	-Музейн танилцуулга. УБ., 2011 он. х.13 -Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II. УБ., 2014 он. х.189 -Музейн танилцуулга. БӨ., 2017 он. х.8 -Өлгий нутгийн өвөрмөц өв соёл. УБ., 2023 он. х.124 -Монголын музейн нэгэн зууны түүх. Архивын баримт, гэрэл зургийн цомог 1924-2024. УБ., 2024 он. х.329	Энэхүү мөнгөн тоногтой хуйтай хутга нь дархны урлагийн нарийн хийц, мөнгөн чимэглэлийн уламжлал, гоёлын хээ угалзын өвөрмөц хэв маягийг бүрэн илэрхийлсэн бүтээл юм. Угсаатны зүйн болон дархны урлал, хэрэглээний соёлын үнэ цэнэтэй, эх хэрэглэгдээхүүний хувьд ховор хадгалагдсан тул “Үнэт дурсгалт зүйл”-ийн зэрэглэлд нэр дэвшүүлж байна.

	Алтан шармал эмээл	БӨМ1972.0.09	1	Эмээлийн бүүрэгний у - 40см. өр - 21см. Урд талын бүүрэгний өн - 11см. Хойд бүүрэгний өн - 9см. Жин - 3840гр. Дөрөөний у - 19см. өр - 13см. / Хос дөрөөний / Жин - 1700гр. Эсгий тохомны у - 43см. өр - 32,5см. Жин - 280гр. Ширэн гөлөмний у - 123см. өр - 49,5см. Жин - 1985гр. Эсгий тохомны у - 54,5см. Жин - 1445гр. Дэвсэгний у - 118,3см. өр - 60см. Жин - 1045гр. Даруулганы у - 60см.	0041631	-Музейн танилцуулга. УБ., 2011 он. х.10 -Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II. УБ., 2014 он. х.206 -Музейн танилцуулга. БӨ., 2017 он. х.6 -Өлгий нутгийн өвөрмөц өв соёл. УБ., 2023 он. х.128	Алтан шармал эмээл нь уламжлалт модон эдлэл, чимэглэлийн дархны урлагийг хослуулсан өнөр түвшний ур хийцтэй бүтээл бөгөөд морин соёлын хөгжлийг илтгэсэн онцгой дурсгал юм. Урлагийн төгөлдөр хийц, ховор нандин байдал, түүхэн болон угсаатны зүйн үнэ цэнийг харгалзан “Үнэт дурсгалт зүйл”-ийн зэрэглэлд нэр дэвшүүлж байна.

				өр - 6,4см. Жин - Хазаарын өр - 2,5см. Оосорын у - 116см. Жин - 960гр.			

Дурсгалт зүйлийн жагсаалтыг гаргасан

Музейн эрдэм шинжилгээний ажилтан Б.Нуржан

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2010 оны 12 сарын 08 ны өдрийн 541 -р
тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УБМС-ийн дугаар: 8301БӨМ 00152

Өмчлөгч: Монгол улс	**РД:**
Эзэмшигч: Баян-Өлгийн аймгийн музей	**РД:** 9006338

Дурсгалын оршин байгаа хаяг: Баян-Өлгий аймаг,Шимширийн Ногайн гудамж, Аймгийн музей
Ашиглалтын байдал: Аймгийн музейн угсаатны зүйн танхимд үзүүллэгт байна.

Дурсгалын нэр: Алтан шармал эмээл	**Хувийн дугаар:** БӨМ1972.0.9а.б.в.г.д.
Орон нутаг, олон улс(шинжлэх ухаан)-ын нэр: "Алтынмен ысталган ер"	

☑ Эх бүтээл ☐ Хуулбар

Зэрэглэл: Зэрэглэлд хамрагдаагүй	**Шийдвэр:** .

Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл
Төрөл зүйл: Угсаатны зүй->Мал аж ахуй, уналга тээвэр
Он цаг: Манжийн ноёрхлын үе / 1691 - 1911 он /, 1972
Бүтээлчийн нэр ба сургууль хийц: Тодорхойгүй, гар хийц
Материал: Мод,төмөр,мөнгө,хүрэн өнгийн хилэн хамба,эсгий,булигаар,хатгамалтай хар өнгийн хилэн хамба,сур

Хэмжээ	Өндөр (см)	Өргөн(зузаан) (см)	урт (см)	Голч (см)	жин (гр)
	0	21	40	0	0
бүүрэгний урд талын өндөр-11см,хойд тал/өн-9см,тохомны урт-124см,гөлөмний урт-118см,өргөн-2,3см					

Гэрэл зураг: 8 ширхэг зурагтай

			
өмнө тал	**ар тал**	**хажуу тал**	**бусад**

Иж бүрдэл: Алтан шармал эмээл 1иж 7 ширхэгээс бүрдэнэ : эсгий дэвсэг-1ш, даруулга-1ш, эмээлийн мод-1ширхэг, давуун дэвсэг-1ш,хазаар-1ш, дөрөө --2ш, битүү тохом-1ш, хөмөлдрөг-1ш.	**Тоо ширхэг:** 1

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн: 1972 онд БӨ аймгийн Улаанхус сумын иргэн Хавдылаас үзмэрт худалдаж авсан байна.

Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр: 1972 онд музейд үзмэрт бүртгэгджээ.

Сэргээн засварласан байдал: Сэргээн засварлаж байгаагүй
СЗБ №:

Хуулбар хийгдсэн байдал: Хуулбар хийгдэж байгаагүй

Тодорхойлолт: Энэхүү алтан шармал эмээл нь маш уран хийцтэй. Казах дархчуудын уламжлалт гар аргаар хийгдсэн байна. Хазаар хөмөлдрөгийг ь алтаар шарсан мөнгөн бааврууудын нарийн уран хийцтэй дахин давтагдашгүй онцгой бүтээл юм.Алтан шармал эмээл нь 1иж 7 ширхэг зүйлээс бүрдсэн.
1. Эмээлийн мод. Бүүргийн урд талд үндэсний хээг төмрөөр гоёж, мөнгөөр өнгөлж алтаар шарсан. Керей омгийн хийцтэй. Бүүргийн урд талд нийтдээ 36ш жижиг дугуй, хойд талд 22ш жижиг дугуй мөнгөн тоногтой.
2. 2ш дөрөө. Мөнгөөр өнгөлсөн үндэсний хээтэй. Хос дөрөө нь бусад эмээлүүдийн дөрөөнүүдээс маш өвөрмөц онцлогтой юм. 3.Эсгий дэвсэг. / энгийн хийцтэй /
4. Даавуун дэвсэгт " Бидай 20 жылдыкка 1960 жыл " гэсэн хатгамалтай.
5.Тохом.Бор өнгийн хээтэй булигаар.Даавуун дотортой.Тохмын 2 талд тус бүрдээ 4-4ш мөнгөлсөн түдүүл төмөртэй. 1 түдүүл төмөр тус бүрд 1ш том 2ш жижиг дугуй мөнгөн тоногтой. 19ш дөрвөлжин хээтэй мөнгөн товруутай.27ш жижиг дугуй тоногтой.Тохмын нөгөө талд дөрвөлжин тоног 20ш.Дугуй / жижиг / тоног 27ш.
6.Хазаар Том цэцгэн хээ-6ш,жижиг цэцгэн хээ-21ш, жижиг дугуй хээ 23ш, нарийн гонзгой хээ 18ш, дөрвөлжин хээ-1ш байна.7. Хөмөлдрөг том цэцгэн хээ 3ш,жижиг цэцгэн хээ -20ш,нарийн гонзгой хээ-50ш,жижиг дугуй хээ-36ш байна.

Гэмтэл өө сэв: Эмээлийн тохомны 1 талд 2ш,нөгөө талд нь 3ширхэг дөрвөлжин тоног унасан байна. Даруулгын 1 оосор нь нилээн урагдсан. 3ш жижиг цэцгэн хээ унасан бөгөөд 1ширхэг босоо гонзгой хээ нь хугарсан гэмтэлтэй байна.

Зориулалт: Морь унах үед хэрэглэх суудалын зориулалттай эд юм.

Ховор түгээмэл байдал: Ховор

Товч түүх: тодорхойгүй

Гарал үүсэл: Казах.

Шилжилт хөдөлгөөн: Уг эмээлийн алтан шармал хазаар, хөмөлдрөг нь 2004 оны 3-р сард Улаанбаатар хотод гаргасан үзэсгэлэнд оролцсон байна. 2005 оны 9-р сард Казахстан улсын нийслэл "Астана " хотод зохиогдсон үзэсгэлэнд.

Судлагдсан байдал: "Улттык мирас ата мура" Өлгий 1991 он.

Хавсралт материалын тэмдэглэл: үгүй

Эзэмшигч өмчлөгчид хадгалагдаж байгаа:

Негатив №: 0 **Слайд №:** 0 **CD / DVD №:** 0 **Дүрс бичлэгийн хуурцаг №:** 1

УНБМСанд хадгалагдаж байгаа:

Негатив №: 0 **Слайд №:** 0 **CD / DVD №:** 0 **Дүрс бичлэгийн хуурцаг №:** 0

Бүртгэлийн бүрдүүлэлт хийсэн: А.Айшагүл, Бүртгэл-мэдээллийн санч, 2009 оны 4 сарын 6 ны өдөр

УНБМСанд хүлээн авсан:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2010 оны 12 сарын 08 ны өдрийн 541 -р
тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УБМС-ийн дугаар: 8301БӨМ 00082

Өмчлөгч: Монгол улс	**РД:**
Эзэмшигч: Баян-Өлгийн аймгийн музей	**РД:** 9006338

Дурсгалын оршин байгаа хаяг: Баян-Өлгий аймаг,Шимширийн Ногайн гудамж, Аймгийн музей
Ашиглалтын байдал: Музейн угсаатны зүйн танхимд үзүүллэгт байна.

Дурсгалын нэр: Мөнгөн тоногтой хуйтай хутга, савх, бэл, хэттэй	**Хувийн дугаар:** БӨМ1960.0.59.1.2.3а.б.4а.б.5
Орон нутаг, олон улс(шинжлэх ухаан)-ын нэр: Мөнгөн тоногтой хуйтай хутга	

☑ Эх бүтээл ☐ Хуулбар

Зэрэглэл: Үнэт	**Шийдвэр:** ..

Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл
Төрөл зүйл: Угсаатны зүй->Гэр зуурын үйлдвэр, гар урлал
Он цаг: Манжийн ноёрхлын үе / 1691 - 1911 он /, 1960
Бүтээлчийн нэр ба сургууль хийц: Бүтээлч нь тодорхойгүй.Гараар хийгдсэн байна.
Материал: Төмөр,мөнгө,эвэр,мод,булигаар

Хэмжээ	Өндөр (см)	Өргөн(зузаан) (см)	урт (см)	Голч (см)	жин (гр)
	0	2.6	46	0	2295
Нэмэлт хэмжээс: бариулын мөнгөн хэсгийн өндөр 3,3см, бариулын мөнгөн хэсгийн өргөн 3,8см, хутганы бариулын эвэрэн ишний өргөн 3,2см,хутганы төмөр үзүүрийн урт 29,8см,					

Гэрэл зураг: 15 ширхэг зурагтай

			
өмнө тал	**ар тал**	**хажуу тал**	**бусад**

Иж бүрдэл: 1иж 7 ширхэг	**Тоо ширхэг:** 7

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн: 1960 онд С.Магзам Сагсай сумын дархан Хуягаас үзүмэрт бэлгээр цуглуулжээ.

Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр: 1960 онд музейн захирлын шийдвэрээр үзмэрт бүртгэжээ.

Сэргээн засварласан байдал: Сэргээн засварлаж байгаагүй
СЗБ №:

Хуулбар хийгдсэн байдал: Хуулбар хийгдэж байгаагүй

Тодорхойлолт: Монгол эр хүний чухал гоёл нь хэт, хутга билээ. Хэт хутгыг бүсэнд зүүх оосрын чимгийг Бэл гэдэг. Бэлийг төмөр, мөнгө, гуулиар хийдэг. Эргэн тойрон хамтай заримдаа дугуй шүрэн шигтгээтэй байдаг. Бэлийн дээд талыг нь голдуу үүлэн, эрвээхэй, эвэр, хээ хэлбэртэйгээр хийсэн байдаг.Болдыг давтаж,сэнж сурвалж тогтоон хадаад шийр булигаар мэтээр улавч тавьж хийсэн гал ноцоох хэрэгслийг "Хэт"гэдэг. Хэтний хээ угалзыг төмөр, мөнгө, сувдаар хийнэ. Хутганы ишийг яс, үйс, сум, мод шахаж алаглан хийх нь буй. Хутганы хуй, иш, ирний ховилыг хээлдэг. Бас алтаар шарж болдог. Хэтийг бүсэнд тэзглүүлэх хаш, мөнгө, ган тэзглүүр гэж байдаг. Мөнгөн хуйтай хутга нь хутга, хуй, мөнгөлсөн 2 модон савх, 2 бэл, хаш тэзгтэй хэтнээс иж бүрдэнэ. Хутганы ишийг эврээр хийж үзүүрийг битүү мөнгөөр бөгжилж, цэцгэн хээ сийлсэн байна. Хутганы уг гуулин бөгжтэй. Хутганы хуй руу ороосон хээгээр хөөмөлдөн мөнгөөр урлажээ. Хуйнаас хэт, бэлээ зүүх сэнжийг луу толгой дүрслэлээр товойлгон хийсэн байна. Модон савхны бөгжилсэн мөнгөтэй хэсгийн урт 11,1см ба арслангийн мөнгөн дүрэмтэй. Бэл нь хоёр булигаар оосортой. Хоёр бэлийг холбосон мөнгөн гинжний урт-53см. Хэт хэтний ар, өвөр талын 2 булан тус бүрд луу хээ,голд нь лууны толгой товойлгон хөөмөлджээ. Хэтнээс хаш тэзгийг сураар холбосон байна. Хаш чулуун тэзг нь ногоовтор өнгийн, найман дэлбээт цэцгэн хэлбэртэй ба хамар угалз хээ, ар талд нь навчин хээ дүрсэлсэн байна.

Гэмтэл өө сэв: Гэмтэл өө сэвгүй

Зориулалт: Монгол эр хүний чухал гоёлын нэг бол хэт, хутга бүсэнд зүүх зориулалттай.

Ховор түгээмэл байдал: Одоо ийм хийцтэй гар урлалын зүйлсийг ингэж гараар урлаж хийдэг хүн ховор учир энэхүү үзмэр нь ховор үзмэрүүдийн тоонд ордог байна.

Товч түүх: Баян-Өлгий аймгийн Сагсай сумын дархан Хуяг гэдэг хүн хийж аймгийн музейд бэлэглэсэн байна. Урд өмнө бусад хүн хэрэглэж байгаагүй байна.

60.59 хувийн дугаартай хуйтай хутганы иж бүрдэл доторх "хэт" нь 2008 оны улсын тооллогод ерөнхий бүртгэлийн дэвтэрт 60.62 гэсэн хувийн дугаараар тустай давхар бүртгээгдсэн учир 2012 оны улсын тооллогын комиссын гишүүдтэй хэлэлцэж давхардлыг арилгаж маргаантай үзмэр эд өлгийн зүйлийн жагсаалтанд бүртгэв.

Гарал үүсэл: урианхай

Шилжилт хөдөлгөөн: 2004 оны 3-р сард Улаанбаатар хотод гаргасан үзэсгэлэнд оролцсон байна.

Судлагдсан байдал: Монгол Улсын угсаатны зүй I бооть

Хавсралт материалын тэмдэглэл: үгүй

Эзэмшигч өмчлөгчид хадгалагдаж байгаа:

Негатив №: 0 **Слайд №:** 0 **CD / DVD №:** 0 **Дүрс бичлэгийн хуурцаг №:** 1

УНБМСанд хадгалагдаж байгаа:

Негатив №: 0 **Слайд №:** 0 **CD / DVD №:** 0 **Дүрс бичлэгийн хуурцаг №:** 0

Бүртгэлийн бүрдүүлэлт хийсэн: А.Айшагүл, Бүртгэл-мэдээллийн санч, 2009 оны 7 сарын 19 ны өдөр

УНБМСанд хүлээн авсан:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2010 оны 12 сарын 08 ны өдрийн 541 -р
тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УБМС-ийн дугаар: 8301БӨМ 00029

Өмчлөгч: Монгол улс	**РД:**
Эзэмшигч: Баян-Өлгийн аймгийн музей	**РД:** 9006338

Дурсгалын оршин байгаа хаяг: Баян-Өлгий аймаг,Шимширийн Ногайн гудамж, Аймгийн музей
Ашиглалтын байдал: Аймгийн музейн угсаатны зүйн танхимд байна.

Дурсгалын нэр: Нөмрөг	**Хувийн дугаар:** БӨМ1960.0.15
Орон нутаг, олон улс(шинжлэх ухаан)-ын нэр: Казак эмэгтэй хүний нөмрөг /желек /	

☑ Эх бүтээл ☐ Хуулбар

Зэрэглэл: Зэрэглэлд хамрагдаагүй	**Шийдвэр:** ...шийдвэрээр

Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл
Төрөл зүйл: Угсаатны зүй->Дээл хувцас, гоёл чимэглэл
Он цаг: БНМАУ-ын үе / 1924 - 1992 он / -> XX зууны дунд үе, дунд үе
Бүтээлчийн нэр ба сургууль хийц: Тодорхойгүй, гар хийц
Материал: Улаан хүрэн, хөх өнгийн торго, булга,

Хэмжээ	Өндөр (см)	Өргөн(зузаан) (см)	урт (см)	Голч (см)	жин (гр)
	0	268.3	156	0	450
нэмэлт хэмжээс : захны урт-14см,цээжний өргөн-37см,суганы өргөн-30см,ханцуйн өргөн-7,2см,хорм/өр-63					

Гэрэл зураг: 5 ширхэг зурагтай



өмнө тал



ар тал



хажуу тал



бусад

Иж бүрдэл: 1 ширхэг	**Тоо ширхэг:** 1

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн: 1960 онд С.Магзам БӨ аймгийн Булган сумаас үзмэрт бэлгээр цуглуулжээ.

Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр: 1960 оны музейн захирлын шийдвэрээр музейд үзмэрт бүртгэгджээ.

Сэргээн засварласан байдал: Сэргээн засварлаж байгаагүй
СЗБ №:

Хуулбар хийгдсэн байдал: Хуулбар хийгдэж байгаагүй

Тодорхойлолт: Уг желекийг улаан хүрэн өнгийн торгоор хийж захны урд хэсгийг булган булгаар эмжиж хөх өнгийн торгоор оедлын машинаар ,,сагат бау,, , ,,шытыра,, хээ гарган ширж оежээ.Желек нь урт хоер ханцуйтай.Ханцуйг мөн оедлын машинаар хөх торгоор эмжсэн байна.

Казах үндэсний малгайн нэг саукеле буюу дээр үед казах эмэгтэйн хадамд гарахад өмсөж явдаг гоёмсог малгайны гадна талаас нөмөрдөг "желек" нь улаан өнгийн торгоор хийгдсэн эмэгтэй нөмрөг. Захны урд хэсгийг булгаар эмжсэн ба цэнхэр өнгийн эмжээрнд "сагат бау шытыра" хээг машинаар оёсон бөгөөд захны урт 14см цээжний өргөн 37см, суганы өргөн 30см, ханцуйн өргөн 7,32см, хормойн өргөн 63см юм. 1960 онд С.Магзам Булган сумаас цуглуулжээ.

Гэмтэл өө сэв: Желекийн духны хэсгийн булган эмжээрийн булганы үс нь их унаж , торго нь гандсан байна.

Зориулалт: Анх казак эмэгтэй хүний хуриманд өмсөх зориулалтаар хийгдэж одоо музейд үзмэрийн зориулалтаар ашиглагдаж байна.

Ховор түгээмэл байдал: Ховор

Товч түүх: 1960 онд БӨ аймгийн Булган сумаас С.Магзам үзмэрт бэлгээр цуглуулжээ.Уг нөмрөг / желек / нь казак үндэсний эмэгтэй хүний хуримын хувцас юм. Саукеле буюу желек гэж нэрлэгддэг бөгөөд желекийг дээр үед казак эмэгтэйчүүд хуриманд өмсөж байсан ба тэр үед хуримаа хийгээд нэг жил өмсөж явдаг байна.Нэг жилийн дараа буюу хүүхэдтэй болох эсвэл тухайн айлаас ямар нэгэн хүн нас барах тохиолдол гарсан үед желекийг тайлаад " Кимешек шылауыш " /толгойн өмсгөл / өмсөж байсан бөгөөд дээр үед казак эмэгтэйчүүд хүзүү болон нүүрээ ил байлгадаггүй уламжлалтай юм.Тийм учраас гэрлэсний дараа нэг жил нөмрөг /желек/ ,дараа нь толгойн өмсгөл /кимешек,шылауыш/ өмсдөг байсан бол одоо үеийн казак эмэгтэйчүүд толгойн өмсгөлийг 60 наснаас хойш өмсдөг болсон бөгөөд одоо казак охидууд хуриманд ,,саукеле,, өмсдөг болжээ.Гэхдээ Саукелег охидууд хуримласан өдөр л өмсдөг байна.

60.15 хувийн дугаартай "Эмэгтэй нөмрөг" (желек) нэртэй үзмэрийг тооллогын салбар комиссын гишүүдтэй хэлэлцэж "Нөмрөг" нэртэй болгож өөрчлөв

Гарал үүсэл: Казах

Шилжилт хөдөлгөөн: 2004 онд Улаанбаатар хотод,2005 онд Казакстан улсын нийслэл Астана хотод тус тус үзэсгэлэнд гаргаж байсан.

Судлагдсан байдал: "Казах улттых кими" 1996он.

Хавсралт материалын тэмдэглэл: үгүй

Эзэмшигч өмчлөгчид хадгалагдаж байгаа:

Негатив №: 0 **Слайд №:** 0 **CD / DVD №:** 0 **Дүрс бичлэгийн хуурцаг №:** 1

УНБМСанд хадгалагдаж байгаа:

Негатив №: 0 **Слайд №:** 0 **CD / DVD №:** 0 **Дүрс бичлэгийн хуурцаг №:** 0

Бүртгэлийн бүрдүүлэлт хийсэн: А.Айшагүл, Бүртгэл-мэдээллийн санч, 2008 оны 9 сарын 10 ны өдөр

УНБМСанд хүлээн авсан: , 2008 оны 9 сарын 10 ны өдөр

МАЯГТ № 2

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2006 оны 56 дугаар тушаалаар батлав

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ

УНБМСангийн дугаар :_____

Зэрэглэл: _____ шийдвэр_____

Өмчлөгч: Монгол улс	**РД:122**
Эзэмшигч: Баян-Өлгий аймгийн музей	**РД:9006338**
Дурсгалын оршин байгаа хаяг:	

Дурсгалын нэр: Саукеле "эмэгтнй хуримын малгай"	
Орон нутаг, олон улс (шинжлэх ухаан) -ын нэр: Саукеле	
Бүртгэлийн дугаар:	**Хувийн дугаар:** БӨМ1960.0.186
Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл	
Ашиглалтын байдал: Аймгийн музейн – Угсаатны зүйн сан хөмрөг	
Төрөл зүйл: Угсаатан зүй-дээл, хувцас-гоёл чимэг	
Он цаг: БНМАУ-ын үе 1924-1992 он	
Бүтээлчийн нэр ба сургууль хийц: тодорхойгүй, гар хийц	
Материал: даавуу, эсгий	

Хэмжээ	өндөр	өргөн /зузаан/	урт	диаметр	жин
	42.5				558

Гэрэл зураг: 21 ширхэг зурагтай



өмнө тал



ар тал



хажуу тал



бусад

Иж бүрдэл: 1 ширхэг

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн: 1960 онд С.Магзам Баян-Өлгий аймгийн Булган сумаас үзмэрт бэлэг дурсгалын замаар цуглуулжээ.

Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр: 1960 онд бүртгэсэн.

Сэргээн засварласан байдал:	**Хуулбар хийгдсэн байдал:** Хуулбар хийгдээгүй байна
СЗБ №	

Тодорхойлолт: Саукеле нь казах үндэстний сүйт бүсгүйн хуримын үеэр өмсдөг уламжлалт өндөр, шовгор хэлбэртэй гоёлын толгойн өмсгөл юм. Өнгө өнгийн үнэт чулуу, сувд, мөнгөн чимэглэлээр гоёж, гоо үзэсгэлэн, аз жаргал, шинэ амьдралын бэлгэдэл болдог.
Гэмтэл өө сэв: Энэхүү үзмэрийн магнайн зүүн талын чихэвч дээр алтан шар саан цацаг хадсан нь халзарч, баруун талд нь цацаг байхгүй байна.
Зориулалт: үзүүллэгийн зориулалттай.
Ховор, түгээмэл байдал: Ховор
Товч түүх:
Гарал үүсэл: казах
Шилжилт хөдөлгөөн: 2005 оны 9-р сард Казахстан улмын Астана хотод 2004 онд Улаанбаатар хотод үзэсгэлэнд гаргасан.
Судлагдсан байдал: Монгоын казахын угсаатны зүй УБ 2016 он
Хавсралт материалын тэмдэглэл: үгүй

Эзэмшигч /өмчлөгч/-д хадгалагдаж байгаа

Негатив № слайд № CD № дүрс бичлэгийн хуурцаг №

УНБМСанд хадгалагдаж байгаа

Негатив №слайд № CD № дүрс бичлэгийн хуурцаг №

Бүртгэлийн бүрдүүлэлт хийсэн: БМС Б.Елик

УНБМСанд хүлээн авсан: _____ .....он.....сар.....өдөр

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УБМС-ийн дугаар: 8301БӨМ 00011

Өмчлөгч: Монгол улс	**РД:**
Эзэмшигч: Баян-Өлгийн аймгийн музей	**РД:** 9006338

Дурсгалын оршин байгаа хаяг: Баян-Өлгий аймаг,Шимширийн Ногайн гудамж,ОНС музей

Ашиглалтын байдал: Баян-Өлгий аймгийн музейн угсаатны зүйн танхимд үзүүллэгт байна.

Дурсгалын нэр: Элгэн дээл	**Хувийн дугаар:** БӨМ1960.0.2
Орон нутаг, олон улс(шинжлэх ухаан)-ын нэр: "Жаргак тон"	

☑ Эх бүтээл ☐ Хуулбар

Зэрэглэл: Үнэт	**Шийдвэр:** 1999 оны захирлын .. тоот тушаалаар

Бүртгэлийн ангилал: Ерөнхий бүртгэл

Төрөл зүйл: Угсаатны зүй->Дээл хувцас, гоёл чимэглэл

Он цаг: Манжийн ноёрхлын үе / 1691 - 1911 он /, XX-зууны эхэн үе

Бүтээлчийн нэр ба сургууль хийц: Тодорхойгүй.

Материал: Хонины элдсэн нэхий,үнэгний год,хурганы арьс,улаан өнгийн даалимба

Хэмжээ	Өндөр (см)	Өргөн(зузаан) (см)	урт (см)	Голч (см)	жин (гр)
	0	0	0	0	1.92
нэмэлт хэмжээс :захны урт-44см,цээжний өргөн -30см, ханцуйн өргөн-12см, хормойн өргөн-49см,					

Гэрэл зураг: 4 ширхэг зурагтай



өмнө тал



ар тал



хажуу тал



бусад

Иж бүрдэл: 1 ширхэг	**Тоо ширхэг:** 1

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн: 1960 онд Баян-Өлгий аймгийн Алтай сумаас музейн үзмэрт бэлгээр авчээ.

Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр: 1960 онд музейд үзмэрт авчээ.

Сэргээн засварласан байдал: Сэргээн засварлаж байгаагүй **СЗБ №:** Үгүй.	**Хуулбар хийгдсэн байдал:** Хуулбар хийгдэж байгаагүй

Тодорхойлолт: Казак үндэсний эмэгтэй хүний дээл. Дээлийг хийхдээ хонины нэхийг гараар элдэж, шар өнгийн байгалийн шороон будганд оруулж будсан байна.Нэхийний өнгөн талын энгэр,ар тал,хормойн хэсэг,ханцуй,тохойн хэсгүүдээр гараар дэгээт зүүгээр үндэсний хээ,цэцэг навч дүрслэн хатгасан байна.Элдсэн үнэгний годон захтай. Дээр үед эмэгтэйчүүд уг дээлийг хавар,намрын улиралд өмсөж байсан ба одоо уг дээлийг хүн болгон хийж өмсөж чаддаггүй учир дахин давтагдашгүй,ховор ,үнэт эд болдгоороо онцлог даавуу талтай юм.

Зориулалт: Казак эмэгтэйчүүд хавар намрын улиралд баяр ёслолын үеэр болон өдөр тутам өмсөж байсан.1960 оноос хойш музейд үзмэрийн зориулалтаар ашиглагдаж байна.

Ховор түгээмэл байдал: Маш ховор дахин давтагдашгүй үзмэр.

Товч түүх: 1960 оны үед музейд үзмэр цуглуулахдаа уг дээлийн Алтай сумаас үзмэрт бэлгээр цуглуулжээ. Чухам хэн ,хэзээ хийсэн гэдэг нь тодорхойгүй байна.

Гарал үүсэл: казах

Шилжилт хөдөлгөөн: 2004 онд Улаанбаатар хотод , 2005 онд Казакстаны Астана хотод ,2007 онд Баян-Өлгий аймгийн Улаанхус,Цэнгэл сумуудад гаргасан түр үзэсгэлэнгүүдэд тус тус гаргаж байсан байна.

Судлагдсан байдал: Монголын казахын угсаатны зүй УБ 2016 он
Биқұмар Моңғолиядағы Қазақтардың дәстүрлері. - Өлгий., 1995

Хавсралт материалын тэмдэглэл: Үгүй

Эзэмшигч өмчлөгчид хадгалагдаж байгаа:

Негатив №: 0 **Слайд №:** 0 **CD / DVD №:** 0 **Дүрс бичлэгийн хуурцаг №:** 1

УНБМСанд хадгалагдаж байгаа:

Негатив №: 0 **Слайд №:** 0 **CD / DVD №:** 0 **Дүрс бичлэгийн хуурцаг №:** 0

Бүртгэлийн бүрдүүлэлт хийсэн: А.Айшагүл, Бүртгэл-мэдээллийн санч, 2008 оны 11 сарын 25 ны өдөр

УНБМСанд хүлээн авсан: